



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 4/266

Мандалговь

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд
шилжүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын гэр хороололд 2008 оны 5 дугаар сарын 1-ээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 3 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг, Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 64 дүгээр захирамжийн хавсралтын 2, 2006 оны 158 дугаар захирамжийн хавсралтын 10, 2008 оны 150 дүгээр захирамжийн хавсралтын 46 дэх заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Хамтран өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

430191761

Аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 22-ны
 өдрийн 366 дугаар захирамжийн хавсралт

№	Газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэн				Газар өмчлөх эрх шилжүүлсэн		Газрын байршил	Газрын хэмжээ /м2/	Газрын үнэ
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистр	Овог нэр	Регистр			
1	Боржигон	Дорждэрэм	Янжинлхам	ЗЮ57110709	Я.Мөнхчимэг	ЗБ88021307	Боржигон 28-2804	750	1800000
2	Зуут	Самдан	Цэцэгмаа	ЗЮ58112421	М.Жамбал	ЗЮ92102339	Мандал 9-926	563	1801600
					М.Батжаргал	ЗФ89040602			
3	Лимбэт	Батчулуун	Янжиндулам	ЗК99112206	Ш.Батчулуун	ЗЮ75013010	Тосгон 7-702	900	2160000
					И.Майшир	ЗИ74112303			
					М.Золзаяа	ЗЮ95031001			
					Б.Цэрэндулам	ЗЮ97040605			